


Сумын Засаг даргын 2021 оны 01-р сарын 28-ны өдрийн 115 дугаар захирамжийн хавсралт



СУМЫН ЗАСАГ ДАРГААС ОЛГОХ ШАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Сум орон нутагтаа ажиллаж, сумын нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл урлаг, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, дэд бүтцийн салбар, гадаад харилцааг хөгжүүлэх, төр засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үйлст бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн амжилт гаргаж байгаа болон сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад өөрийн хувь нэмрээ оруулсан тус сумын иргэнийг Шивээговь сумын Засаг даргын шагналаар шагнуулах, нэр дэвшүүлэх, уламжлах өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР . СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ТӨРӨЛ

2.1 Сумын Засаг даргаас олгох шагнал нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

1. Сумын “Оны онцлох байгууллага”
2. Сумын “Оны тэргүүний ажилтан”
3. Сумын Засаг даргын “Баярын бичиг”
4. Сумын “Аварга малчин өрх”
5. Сумын “Алдарт уяач”
6. Сумын “Тэргүүний газар тариаланч”
7. Сумын “Тэргүүний сурагч”
8. Сумын “Мянгат малчин”
9. Соёлын биет бус өв өвлөн уламжлагч

ГУРАВ.ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ ,ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Сумын Засаг даргын шагналд тодорхойлогдож байгаа нэр дэвшигч нь дор дурдсан болзол, шалгуурын хангасан байна. Үүнд:

3.1.1 Сумын “Оны онцлох байгууллага”

Сумын нийгэм, эдийн засгийн хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хамт олныг тухайн жилийн “Оны онцлох байгууллага”-аар шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

“Оны онцлох байгууллага”-д нэр дэвшиж байгаа аж ахуй нэгж, байгууллага нь татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй, төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн, байгууллагын орчны тохижилт нь жишиг болохуйц, тухайн байгууллагын ажилтан албан хаагчдаас гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилладаг, аймаг, сумын ард, иргэдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн байна.

3.1.2 Сумын “Оны Тэргүүний ажилтан”

Төрийн зорилт чиг үүргийг хуулийн хүрээнд хариуцлагатай гүйцэтгэн төрийн албанд тавигдах үндсэн шаардлага, албан хаагчийн ёс зүй, шударга байдлыг эрхэмлэн хариуцсан ажилдаа санаачлагатай, идэвхи зүтгэл гарган ажиллаж тухай жилийн ажлаараа сумандаа тэргүүлж манлайлсан төрийн албан хаагч байна.

Оны Тэргүүний төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагчийг дараах салбар чиглэлээр шалгаруулна.

а/ Төрийн албан хаагч /боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, үйлчилгээний ажилтнууд/

1. Төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн иргэд олон нийтийн сэтгэл ханамжаар хангалттай сайн гэсэн үнэлгээгээр үнэлэгддэг байх.
2. Салбартаа тэргүүлэн улс, аймагт гаргасан амжилтыг харгалзах
3. Үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээнээс гадна өөрөө санаачлан хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний үр дүн
4. Сум орон нутаг, байгууллагаас зохион байгуулагддаг олон нийтийн арга хэмжээнд манлайлан оролцдог байдал.
5. Тухайн жилд сахилгын шийтгэл оногдоогүй байх.